

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
НОМЫН САН**



Шинэ номын мэдээ

2018.06

№ 03

Эмхтгэсэн: Ном зүйч С.Найгалмаа

Ном зүйч У.Гэрэлтуяа

**Электрон каталоги:
<http://catalog.num.edu.mn>**

ГАРЧИГ

БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ	1
УХААН.....	
ГАЗАРЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН.....	1-3
БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ	3-5
УХААН.....	
ТЕХНИК БА ТЕНИКИЙН ШИНЖЛЭХ	5
УХААН.....	
ХӨДӨӨ АЖ АХУЙ БА ОЙН АЖ	5-7
АХУЙ.....	
ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ АНАГААХЫН ШИНЖЛЭХ	7-9
УХААН.....	
ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ	9-16
УХААН.....	
ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ	17-19
УХААН.....	
УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ	20-21
УХААН.....	
ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ	21-24
УХААН.....	
ШИНЖЛЭХ УХААН. ШИНЖЛЭХ УХААН	24-25
СУДЛАЛ.....	
БОЛОВСРОЛ. СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ШИНЖЛЭХ	25-26
УХААН.....	
СЭТГҮҮЛ	26-29
ЗҮЙ.....	
ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ	29-30
УХААН.....	
УТГА ЗОХИОЛ	31-32
СУДЛАЛ.....	
УРАН	33-40
ЗОХИОЛ.....	
УРЛАГ. УРЛАГ	40
СУДЛАЛ.....	
ШАШИН	41-42
СУДЛАЛ.....	
ГАДААД ХЭЛ ДЭЭРХ	42-44
НОМ.....	

Товчилсон үгийн тайлбар:

БУН-Байгалийн ухааны номын уншлагын танхим /306тоот/
НУН-Нийгмийн ухааны номын уншлагын танхим /211тоот/
ГНОФ-Гэрээр ном олгох фонд /109, 110тоот/
ГФ-Гадаад номын фонд /411тоот/
ЭШФ-Эрдэм шинжилгээний фонд /411тоот/
БС-Бизнесийн сургуулийн номын сан /Хич-V 505тоот/
ХЗС-Хууль зүйн сургуулийн номын сан /Хич-III 205тоот/
ОУХНУС-Олон улсын харилцаа. Нийтийн удирдлагын
сургуулийн номын сан /Хич-V 304тоот/

БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ. ЭКОЛОГИ



Биологийн олон янзын байдлын хамгаалал, ОНТХГН-Нөхөрлөлүүдийн тухайлсан зүйл амьтдын мониторинг судалгааны ойлголтууд: Гарын авлага / Боловс. Д.Энхбилэг, Г. Майнжаргал; Хян. Б.Оюунтүлхүүр.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 123х.- (Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам. Ерөнхий болон Сорилын Биологийн Хүрээлэн).

Энэхүү гарын авлагыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Даян дэлхийн байгаль орчны сангийн буцалтгүй тусламжаар БОАЖЯ-тай хамтран хэрэгжүүлж буй “Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ” МОН/13/303 төслийн хүрээнд бэлтгэн, байгаль хамгаалагч нарт зориулан хэвлүүлэв.

20.18

Б-490

ЭШФ Б-28334

ФИЗИК. МАТЕМАТИКИЙН ШИНЖЛЭХ УХААН

Мөнх-Очир Д. Он цаг тоолол ба мянга хорин жилийн шар зурхайн цаглабар: 1000-2019: 1000 оноос 2019 он хүртэл Арга-Билгийн тооллыг НАСА-аас гаргасан сарны тоололтой харьцуулсан цаг тооллын хүснэгт / Хян. Ж.Урангуа.- УБ., 2014.- 415х.- ISBN 978-99929-855-0-X.



Энэхүү цаг тооллын түүхэн хөгжлийн нэг сэдэвт судалгааны бүтээлд Монголчуудын цаг тоолол хэрэглэж ирсэн түүхэн уламжлал, бидний өвөг дээдэс шинжлэх ухаанд ямар гайхамшигтай өөрчлөлт, шинэчлэлт хийж ирснийг бага боловч таниулахыг зорьжээ.

22.6

М-816

ЭШФ Б-28560

ГАЗАРЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН



Дэмбэрэл Б. Хэрэглээний геодези / Хян. Ю.Чүлтэм.- УБ.: Адмон, 2018.- 278х.- ISBN 978-99978-1-672-6.

Энэ номонд геодези, байр зүй, зураг зүй, геодезийн хэмжилтийн багаж хэрэгслийн тухай үндсэн ойлголт, хот суурин газар, авто болон төмөр зам, гүүр далан, нисэх онгоцны буудал, усан цахилгаан станц, газрын тос хийн хоолой, нүхэн байгууламж төсөллөх, барьж байгуулах, ашиглах үеийн геодезийн хэмжилтийн ажил гүйцэтгэх арга, нарийвчлал,

хэмжилтийн үр дүнг боловсруулах тухай болон хэв гажилт тодорхойлох геодезийн хэмжилтийн ажлын арга, онцлог зэрэг орсон болно.

26.1

Д-901

/БУН унш-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Т-21651-21653

Жанчивдорж Л. **Усны менежментийн англи-монгол-орос толь** / Ред. Д.Сайзмаа, Д.Оюунцэцэг.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 462х.- ISBN 978-99978-0-706-9.



Энэхүү толь бичиг нь усны нөөцийн судалгаа, усны барилга байгууламжийн хайгуул төсөл, барилга угсралт, ашиглалт, эрдэм шинжилгээний ажлын хүрээнд 20000 орчим нэр томъёог багтаасан бөгөөд усны аж ахуйн тооцоо, усны нөөцийг ашиглах, хамгаалах ажлын төлөвлөлт, услалт хамгаалалтын систем, усан цахилгаан станц, үер, бохир ус цэвэрлэх зэрэг ус хэрэглэх, ашиглахтай холбоотой мэргэжлийн үгтэй ажээ. Толийг усны мэргэжлийн байгууллагад ажиллагсад, судлаачид, усны болон зам барилгын инженер, усны салбарын мэргэжлийн оюутан, орчуулагчдад зориулав.

26.22я2

Ж-288

/БУН унш-4ш/

ЭШФ Т-21548-21550



Эрдэнэсүх С., Сандэлгэр Д. **Цаг уурын бодлогын хураамж** / Ред. М.Цоозол.- УБ.: Удам соёл, 2018.- 178х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх Ухааны Сургууль).- ISBN 978-99978-2-249-9.

Энэхүү бодлогын хураамжид цаг уурын хэмжигдэхүүнүүдийн хоорондын холбоо, агаар мандлын статик ба термодинамик, дэлхий агаар мандлын системийн ба газар орчмын агаарын үе давхаргын дулааны горим, агаарын хөдөлгөөн, агаар мандал дахь усны уурын тооцоо хийх стандарт дасгал бодлого, зарим онцлог тооцоо хийх бодолтыг оруулжээ.

26.23

Э-739

/БУН унш-10ш, ГНОФ-15ш/

ЭШФ Б-28356-28360

Бямба Ж., Энхбаатар Б. **Стратиграфийн үндэс** / Ред. Д.Доржнамжаа, Я.Ариунчимэг.- 2 дахь хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 201х.- ISBN 978-99978-2-063-1.



Энэхүү сурах бичигт стратиграфийн шинжлэх ухааны зүйл болох стратиграфийн биетүүдийг бүрдүүлэгч чулуулгийн төрлүүд, тэдгээрт стратиграфийн судалгаа явуулах зарим онцлогийн тухай товч ойлголт өгчээ. Мөн стратиграфийн шинжлэх ухаанд хэрэглэдэг литологи, палеонтологи, хронологи, геохими, радиологи зэрэг аргуудад дээж

хэрхэн авах, үр дүнд хэрхэн боловсруулалт хийх талаар оруулсан бөгөөд геологичид, газар зүйчид, их дээд сургуулийн геологийн мэргэжлээр суралцагч оюутнуудад зориулжээ.


26.31я73

Б-984

/БУН унш-5ш, ГНОФ-7ш/

ЭШФ Т-21551-21553

БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц: (CITES)-ийн лавлах / Ред. Б.Чимэддорж, С.Пүрэвсүрэн, Х.Тэрбиш.- УБ., 2018.- 448х.- ISBN 978-99978-938-1-9.

Энэхүү бүтээлд “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц”-ийн албан ёсны орчуулгыг бүрэн эхээр нь, амьтан ургамлын нэршил, ховордлын зэрэглэл, таних шинж, тархалт, тоо толгой, хомсдох шалтгаан, худалдаа, хамгаалсан байдал, экологи, эдийн засгийн үнэлгээ ба хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэргийг тодорхой оруулжээ.

28.0

3-964

/БУН унш-5ш, ГНОФ-10ш/

ЭШФ Т-21682-21686

Монгол орны хагийн зурагт лавлах: “Монгол орны гербарийн сан”-ийн хагийн фонд материалаас / Эмхт. О.Энхтуяа, С.Жавхлан.- УБ.: Бемби сан, 2017.- 218х.- ISBN 978-99978-1-863-8.


Энэхүү зурагт лавлахад 210 зүйл хагийн лавлах анхдагч материалыг толилуулахын зэрэгцээ тэдгээрийн зарим нэршилд сүүлийн үед баримталж буй номенклатур нэршлийг оноож өгчээ. Эдгээр цөөн тооны хагаар төлөөлүүлэн хаг биотын олон янз байдал, гадаад морфологи төрхийг 16х4 дахин өсгөн буулган авч баримтжуулан оруулсан нь байгаль судлаач, оюутан залуус, сонирхогч олон нийтэд тэдгээрийг танин мэдэхэд чухал ач холбогдолтой болжээ.

28.591(1)я6

М-692

/БУН унш-3ш/

ЭШФ Б-28544-28546



Амьтан судлалын ангилалзүйн товч лавлах / Орч. Ч.Чулуунжав, Н.Энхболд; Хян. Б.Дорж.- УБ.: Адмон принт, 2017.- 131х.- ISBN 978-99978-1-265-0.

Байгалийн шинжлэх ухаан үсрэнгүй хурдтай хөгжиж буй өнөө үед ургамал, амьтны тархалт, амьдрах орчны онцлог, биологийн нөхцлийн

адил төстэй талыг харгалзан шинжлэх ухааны шинэ салбарууд бий болж төдий хэрээр нэр томъёонууд гарч байна. Энэхүү ном нь орчин үеийн амьтан судлалын ангилалзүйн чиглэлээр ажилладаг хойч үеийн залуу судлаачдын танин мэдэхүйг хөгжүүлж, судалгаа шинжилгээний ажилд нь мөрдлөг болохуйц бүтээл юм.

28.69я2

Н-41

/БУН унш-5ш/

ЭШФ Б-28611-28613

Монгол орны ойн шавж / Ж.Пунцагдулам, Д.Алтанчимэг, Д.Энхнасан, Б.Ганзориг; Ерөн. ред. Ж.Пунцагдулам; Ред. Б.Намхайдорж, Д.Жагдаг.- УБ.: Адмон принт, 2017.- 316х.- ISBN 978-99978-2-140-9.



Энэ номонд ойн хөнөөлт шавж олширсон тохиолдолд тэдгээртэй тэмцэх аргыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ойг хамгаалах ажилд хэрэглэх техник, технологийн тухай уламжлалт болон орчин үеийн арга ба журмын тухай өгүүлнэ. Уг ном нь үндсэн зургаан хэсгээс бүрдэх бөгөөд ойг хөнөөлт шавжаас хамгаалахын тулд шавжийн төрөл зүйл, биеийн бүтэц, амьдралын онцлог, шавжийн аймгийн тухай ерөнхий ойлголт, ангилал зүйг товч оруулжээ. Энэхүү номыг эрдэм шинжилгээний ажилтан, ойн ангийн инженер, мэргэжилтэн, байгаль хамгаалагч, ой судлал, шавж судлалын чиглэлээр суралцаж буй оюутнуудад зориулав.

28.691.89(1)

М-692

/БУН унш-5ш/

ЭШФ Б-28570-28573



Цагаанцоож Н. Навч шилмүүсний хөнөөлт шавж яacobсоны төөлүүр (ERANNIS JACOBSONI DJAK.) эрвээхийн биологи экологи, хамгаалах арга хэмжээ / Хян. Ж.Пунцагдулам.- УБ.: Адмон принт, 2017.- 99х.- ISBN 978-99978-2-152-2.

Тус номонд ойд сөрөг нөлөө үзүүлдэг анхдагч хөнөөлт шавж буюу навч шилмүүсээр хооллож гэмтэл учруулдаг эрвээхийг судлах арга, тэдгээр шавжийн олшроход нөлөөлдөг хүчин зүйл, анхдагч хөнөөлт шавжийн нөлөөгөөр хоёрдогч хортон шавж буюу модлог идэшт шавж олшрох зүй тогтол, хөнөөлт шавжтай тэмцэх аргын талаар өгүүлснээс гадна хөнөөлт шавжтай хийсэн тэмцлийн ажлын дүнг тусгажээ. Энэ ном нь ойн аж ахуй, түүний шинженер, мэргэжилтэн, ойн шавж судлалаар судалгаа хийдэг эрдэм шинжилгээний ажилтан, биологи, ой, шавж судлал, байгаль хамгааллын чиглэлээр суралцаж буй оюутнуудад гарын авлага болох юм.

28.691.89

Ц-126

/БУН унш-5ш/

ЭШФ Т-21592-21595

Цагаанцоож Н., Батчөдөр Б. **Модлог идэшт шавж, тэдгээрээс хамгаалах арга** / Ред. У.Айбек.- УБ.: Адмон принт, 2017.- 116х.- ISBN 978-99978-1-959-8.



Энэхүү номонд манай орны ойг үүсгэгч шилмүүст модны модлог идэшт шавжийн судалгааг тодорхой ой бүхий орчинд явуулан, мод бэлтгэсэн, түймэрт шатсан, доройтолд орсон ойн талбай тус бүрээр нь шавжийн зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлон, уур амьсгал болон бусад хүчин зүйлүүдийн нөлөөлөлтэй нь холбож үзсэн туршилт судалгааны үр дүнг тусгажээ. Энэ ном нь ой судлаач, ургамал судлаач, экологич, биологи ба хөдөө аж ахуйн мэргэжлийн их дээд сургуулиудын багш, доктрант, магистр, оюутнууд болон ойн аж ахуй хэрэглэгчдэд оюуны болон аж ахуйн хэрэгцээнд нь зориулагджээ.


28.691.89

Ц-126

/БУН унш-5ш/

ЭШФ Т-21588-21591

РАДИО. ЭЛЕКТРОНИК



Мягмаржав Ч. **Auto Cad 2016** / Ред. Б.Батсүрэн.- Анхны хэвл.- УБ.: Тод бичиг, 2017.- 290х.- ISBN 978-99978-2-170-6.

Энэхүү ном нь Auto Cad-ийн аль ч версед ашиглах боломжтой бөгөөд онолын мэдлэгийг бататгах жишээ, дасгал, процессийн дарааллыг түлхүү оруулсан нь зургийн Cad програмыг сонирхогч хэн бүхэнд туслах болно.

32.973.26-018.2

М-985

/БУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-21654-21656

ХӨДӨӨ АЖ АХУЙ БА ОЙН АЖ АХУЙ

Монгол орны хөрс, газрын гадарга: Дэлхийн хөрсний өдөрт зориулсан үндэсний эрдэм шинжилгээний онол практикийн бага хурлын эмхтгэл.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2015.- 172х.- (Монгол Улсын Их Сургууль).




Тус эмхтгэлд хөрсний судалгааны ажлын түүх, хөрсний тархалт, ангилал, үржил шимийг сайжруулах, бордох, хөрсний бохирдлын өнөөгийн түвшин, сайжруулах, бордох, хөрсний элэгдэл, эвдрэл, хөрсний бохирдол хүний эрүүл мэндэд нөлөөлж буй байдал зэрэг асуудлыг тал бүрээс хөндсөн илтгэл, өгүүллийг эмхтгэсэн.

40.3(1)

М-692

/БУН унш-5ш/

Т-21665-21669



Ариунзул Я. Ойн менежментийн төлөвлөгөөг хиймэл дагуулын мэдээ ашиглан сайжруулах: Зөвлөмж.- УБ., 2017.- 87х.

Тус номонд өнөөгийн Монгол орны ойн төлөвлөлт ойн сангийн өөрчлөлтийг хэрхэн тооцож байгаа байдал, мөн хиймэл дагуулын мэдээг ойн менежментийн төлөвлөгөөнд ашигладаг эсэхийг судалж AFPNet, ERISC байгууллагуудын богино хугацааны төслөөр ойн бүрхэвчийн өөрчлөлт тооцсон үр дүнг бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх түвшинд хэрхэн ашиглаж болох, ойн тогтвортой менежментийг бий болгох санал зөвлөмжийг дэвшүүлжээ. Энэхүү номыг ойн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг албан байгууллага, нөхөрлөлийн гишүүд, судлаач, ойн чиглэлээр суралцагч оюутнууд болон сонирхсон хэн бүхэн ашиглах боломжтой юм.

43+65.34

А-751

/БУН унш-5ш/

ЭШФ Б-28624-28627

Ариунзул Я. Хиймэл дагуулын мэдээ ашиглан ой тодорхойлох арга зүй: Гарын авлага.- УБ.: Хөх монгол, 2017.- 126х.- (AFA Net., ERISC MONGOLIA).




Энэхүү номыг тандан судлал, орон зайн мэдээ ашигладаг, газар зүйн мэдээллийн системтэй харьцдаг мэргэжилтэн, судлаач, оюутнуудад зориулав.

43


А-751

/БУН унш-5ш/

ЭШФ Т-21657-21660



Ойн нэвтэрхий толь / Ерөн. ред. Ч.Доржсүрэн, Ч.Дугаржав.- УБ.: Адмон принт, 2017.- 554х.- ISBN 978-99978-2-029-7.



Энэхүү нэвтэрхий толь бичигт ой судлал, мод судлал, модлог судлал, хөрс судлал, ургамал судлал, амьтан судлал, шавж судлал, экологи, биологийн шинжлэх ухааны үндсэн ойлголтууд, ой модыг хамгаалах, нөхөн сэргээх, ойг тарьж ургуулах, зүй зохистой ашиглах арга технологи, ойг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн болон иргэний нийгмийн байгууллагын тухай 1365 нэр томъёог оруулав. Мөн ой бүрдүүлэгч мод, сөөг, амьтан, ургамал, мөөг, хагны төрөл зүйлийг аль болох өргөн хамруулсан бөгөөд монгол нэрийн ард латин нэрийг хавсаргажээ. Уг ойн нэвтэрхий толь нь ойн аж ахуйн мэргэжилтнүүд, ойн аж ахуйн чиглэлээр суралцагсад, магистр, доктор, тусгай мэргэжлийн сургуулийн сурагч нар төдийгүй ой мод сонирхогч уншигч олонд зориулагдсан байна.


43я2+20.1я2

О-239

/БУН унш-5ш, Лав-1ш/

ЭШФ Т-21584-21587

Ариунзул Я., Батчулуун Ц. **Монгол орны ойн бүрхэвчийн өөрчлөлт.**- УБ., 2017.- 296х.- (AFA Net., ERISC MONGOLIA).



Монгол орны ойгоор бүрхэгдсэн талбайн 15 жилийн мэдээллийг Ландсат хиймэл дагуулын мэдээгээр тодорхойлох маш их цаг хугацаа, хөрөнгө шаардсан энэ ажил нь Монгол орны ойн салбарт дахин хийгдэхгүй зөвхөн шалгаж, сайжруулаад явах боломжтой мэдээлэл гэж төслийн багийнхан үзээд судалгааны материалыг ой судлаач, мэргэжилтэн, оюутнуудад зориулан энэ номоор хүргэж байна.

43(1)

A-751

ЭШФ Т-21661-2166

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ. АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААН



Лхагва Л. **Судлаад баршгүй эрдмийн далай:** Сонгомол бүтээлүүд: Боть-I / Ред. Ж.Энхцэцэг.- УБ.: Мөнхийн үсэг, 2014.- 230х.- ISBN 978-99973-2-729-1.

Энэхүү номд зохиогчийн сансрын биологи, анагаах ухааны судалгааны хүрээнд сансрын физиологи, биохэмнэл судлал, биоанагаахын чиглэлээр гадаад, дотоодын сэтгүүл болон номд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүллүүдээс гадна түүний диссертацийн хураангуй оржээ.

51+28.089

Л-874

ЭШФ Б-28597

Лхагва Л. **Судлаад баршгүй эрдмийн далай:** Сонгомол бүтээлүүд: Боть-II / Ред. Ж.Энхцэцэг.- УБ.: Мөнхийн үсэг, 2015.- 209х.- ISBN 978-99973-2-730-7.



“Судлаад баршгүй эрдмийн далай” хэмээх энэхүү номд зохиогчийн туурвисан эрдэм шинжилгээний бүтээлүүдийн багахан хэсэг орсон бөгөөд түүний сансрын биологи, биохэмнэл судлал, биоанагаахын чиглэлээр гадаад, дотоодын сэтгүүл, номд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүллүүдийг нийтэлжээ.

51+28.707.3

Л-874

ЭШФ Б-28598



Лхагва Л. **Судлаад баршгүй эрдмийн далай**: Сонгомол лекцүүд: Боть-III / Ред. Г.Отгон.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 202х.- ISBN 978-99973-2-181-2.

“Судлаад баршгүй эрдмийн далай” хэмээх энэхүү номын гуравдугаар ботид зохиогчийн сансрын физиологи, хронофизиологи, хрононэмгэг судлал, хронофармакологи, сансрын биоанагаахын туршилт, судалгаа зэрэг сэдвээр туурвисан эрдэм шинжилгээний бүтээлүүд багтжээ.

51+28.089

Л-874

/БУН унш-2ш/

ЭШФ Б-28599-28601

Лхагва Л. **Судлаад баршгүй эрдмийн далай**: Сонгомол бүтээлүүд: Боть-IV / Ред. Ё.Думаа.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 261х.- ISBN 978-99978-2-182-9.

“Судлаад баршгүй эрдмийн далай” хэмээх энэхүү номын дөрөвдүгээр ботид зохиогчийн хүний физиологи, тамирчдын физиологи, нанотехнологи, наноанагаах ухаан, наноэм зүй зэрэг сэдвээр туурвисан эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, лекцүүд багтжээ.



51+28.089

Л-874

/БУН унш-2ш/

ЭШФ Б-28602-28604



Кутушов М.В. **Толин тусгалт өвчин**: Хавдар, чихрийн шижин, шизофрени, харшил / Орч. М.Нарантуяа, Ш.Эрдэнэчимэг, Л.Уранцэцэг ба бус.; Хян. Б.Туяа, М.Дэлгэржав, Ш.Эрдэнэчимэг.- УБ.: Адмон принт, 2016.- 296х.- ISBN 978-5-88923-306-0.

Тус номонд амьд субстанции болон огторгуй хоорондын төстэй байдлын талаарх таамаглал, түүнийг баяжуулсан үзэл баримтлалыг танилцуулаад, амьд болон амьгүй байгалийн өөрийн зохион байгуулалтад оролцдог төстэй хэлбэрт шилжих, автоморфизм, гурвалсан хүчин зүйлийн нэгдэл, дуализм буюу хоёрдмол шинж, спираль загварчлал болон морфологийн бусад бүтцийг дүрслэн тайлбарлажээ. Энэхүү номыг эрдэмтэд, эмч нар, эрүүл мэндийн болон биологийн чиглэлээр суралцаж буй их, дээд сургуулийн оюутнууд, хавдраар өвчлөгсөд болон өргөн олонд зориулав.

52

К-95

/БУН унш-7ш ГНОФ-5ш/

ЭШФ Б-28075-28077

Хүрэлбаатар С. **Ховс: Био орон зайн өвчлөл, эмчилгээ** / Ред. Б.Долгор.- УБ., 2012.- 230х.- ISBN 978-99962-1768-5.

Зохиогч энэ номондоо сүүлийн үед хүмүүсийн сонирхлыг асар ихээр татаж байгаа ховс, био орон зай, далд ухамсар, сүнс болон энэ сонирхолтой



зүйлсийг эмчилгээтэй холбож, орчин үеийн анагаах ухаанд судлагдаагүй, хэрэглэж нэвтрээгүй био орон зай, ховсоор эмчлэх арга ухааныг өөрийн 20 жилийн туршлага дээрээ тулгуурлан тайлбарлажээ.

53.57

X-840

ЭШФ Б-28550-28552



Кутушов М.В. **Хорт хавдар: Домог ба бодит байдал** / Орч. Ш.Эрдэнэчимэг; Хян. Б.Туяа, М.Дэлгэржав.- УБ.: Адмон принт, 2015.- 164х.- ISBN 798-5-888923-306-0.

Эрт үед хорт хавдраар зөвхөн хижээл болон өтөл насны хүмүүс өвчилдөг байсан бол өнөөгийн экологийн нөхцөлд ийм өвчтэй залуучууд, түүнчлэн хүүхдүүдийн тоо өссөөр байна. Тэгэхээр хорт хавдар бол амьдарч буй орчин нөхцлийн тусгалт дэлхий нийтийн өвчин юм. Хорт хавдрын мөн чанар, гарал үүслийг хүн төрөлхтний төлөөлөл болох тодорхой нэг хүний геномыг судалснаар илрүүлж, эмчилэх боломжгүй юм. Тэгвэл уншигч та энэхүү номыг уншсанаар хорт хавдартай олон хүн эдгэрсэн тухай мэдэх болно.

55.6

K-95

/БУН унш-4ш/

ЭШФ Б-28078-28080

ТҮҮХ. ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН

Мөнх-Очир Д. **Ханхөгшин хошууны 1927 оны хүн амын тооллого.**- УБ.: Удам соёл, 2014.- 336х.- (Цэцэрлэг Мандал аймгийн Ханхөгшин хошууныхны ураг удам).- ISBN 978-99973-64-92-0.




Энэ номонд 1923 оны эхээр Ардын Засгийн газраас “Монгол улсын нутгийн захиргааны дүрэм”, “Засаг ба засаг бус ван гүн нарын эрх хэмжээний дүрэм” зэргийг гаргаж, Сайн ноён хан аймгийн Сайн ноён хошууг Цэцэрлэг мандал уулын аймгийн Ханхөгшин уулын хошуу болгон өөрчилсөн нь одоогийн Өвөрхангай аймгийн Арвайхээр, Баруунбаян-улаан, Бат-Өлзий, Богд, Гучин-Ус,, Нарийнтээл, Хайрхандулаан, Уянга болон Баянхонгор аймгийн Өлзийт, Эрдэнэцогт сум бөгөөд энэ нутгийнхны өвөг дээдсийн ураг удмын бүртгэлийг тодруулах үүднээс Төв архивт хадгалагдаж буй 1927 оны хүн амын тооллогын баримтыг оруулжээ.

60.7(1)+63.5(1)

M-816

ЭШФ Б-28561



Хидэхиро О. **Дэлхийн түүх мэндэлсэн нь** / Орч. П.Наранбаяр; Ред. Т.Мөнхцэцэг.- 3 дахь хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 176х.- (Монгол Улсын Их Сургууль. Монгол Судлалын Хүрээлэн).- ISBN 978-99962-885-4-8.

Зохиолч энэ номондоо XIII зууны эхэнд Чингис хааны байгуулсан эзэнт улс түүний ач нарын үед зүүн талдаа Япон тэнгисээс баруун зүгт Оросын тал нутаг, өмнө талдаа Өмнөд Хятадын тэнгисээс өнөөгийн Ираны өндөрлөг хүрсэн өргөн уудам газар нутгийг нэг үндэстний захиргаанд оруулснаар Монголын эзэнт гүрэн түүхэнд анх Ази, Европыг шууд холбож, Евразийн эх газрын өрнө дорнын харилцааг идэвхижүүлсэн төдийгүй XV зуунд Европын далайн эрин үе эхлэхэд ч угтаа Монголын эзэнт гүрэн нөлөөлсөн гэсэн санааг дэвшүүлжээ.

63.3(0)

X-347

/НУН унш-8ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-21626-21630

Дашцэрэн Б. **Монгол улсын шинэ түүхийн он дарааллын товчоон:1921-1957** / Эмхт. Да.Эрдэнэбат, Л.Ганбат; Хян. З.Лонжид.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 294х.- ISBN 978-99978-0-683-3.




Энэ номонд 1921-1957 оныг хамарсан Монголын шинэ үеийн түүхэнд холбогдох чухал үйл явдлуудыг товч тайлбартайгаар он цагийн дараалалаар жагсаан эмхтгэжээ.

63.3(1)

Д-39

/НУН унш-5ш/

ЭШФ Б-28532-28534



Хүүхэнбаатар Д. **Эрдэнэзуу хийдийн түүхээс: Монгол гүрний элчин харилцаа (XIII зуун): Монголын соёлын түүх** / Эрхл. П.Дэлгэржаргал.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 196х.- ISBN 978-99978-58-38-2.

Профессор Д.Хүүхэнбаатар МУИС-д 48 дахь жилдээ багшилж, мянга мянган шавь төрүүлсэн эрхэм хүндтэй сурган хүмүүжүүлэгч юм. Тэрээр нэгэн сэдэвт зохиол гурав, 20 шахам хамтын бүтээлд оролцон туурвиж, эрдэм шинжилгээний олон арван өгүүлэл хэвлүүлсний зэрэгцээ судалгааны ажлынхаа үр дүнг гадаад дотоодод болсон эрдэм шинжилгээний 40 гаруй хуралд илтгэл тавин хэлэлцүүлж нийтийн хүртээл болгосон байна. Түүний 80 насны ойд зориулан “Эрдэнэзуу хийдийн түүхээс” (1962), “Монгол гүрний элчин харилцаа” (1964), “Монголын соёл” (1968) бүтээлүүдийг эмхтгэн дахин хэвлүүлж та бүхэнд хүргэж байна.


63.3(1)

X-85

/НУН унш-3ш/

ЭШФ Б-27214-27215

Профессор Д.Хүүхэнбаатар багшийн мэндэлсний 80 жилийн ойд зориулсан дурсамж хүндэтгэлийн хурал / Эрхл. П.Дэлгэржаргал.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 232х.




МУИС-ийн Түүхийн тэнхимээс хүндэт профессор Дашдаваагийн Хүүхэнбаатар багшийн мэндэлсний 80 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан түүнд зориулсан дурсамж, хүндэтгэлийн хурлыг 2017 оны 11 сард зохион байгуулсан билээ. Энэхүү номонд түүний бүтээлийн жагсаалтууд, шавь нар болон хамт ажиллаж байсан багш сурган хүмүүжүүлэгч нарын тавьсан илтгэлүүд, зургийн цомог зэргийг багтаажээ.

63.3(1)г

П-84

/НУН унш-3ш/

ЭШФ Б-27216-27217



Ахбар-э Моголан буюу Монголчуудын элдэв сонин / Орч. Д.Анхбаяр; Эрхл. Д.Заяабаатар.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 170х.- (Монгол Улсын Их Сургууль. Монгол Судлалын Хүрээлэн).- ISBN 978-99978-58-48-1.

Монголын эзэнт гүрний түүхэнд холбогдох Ил хаант улсын үеийн Перс хэлээрх сурвалжийн түүх бичлэгийн судалгаа, сурвалжийг орчуулан нийтлүүлжээ.

63.3(1)4

А-893

/НУН унш-8ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-21631-21635

XX зууны эхэн хагас үе ба Монголчууд / Эмхт. Ц.Ганбагана.- УБ.: Удам соёл, 2017.- 267х.- ISBN 978-99978-1-416-6.



Энэхүү ном нь Монголын XX зууны эхэн хагасын үеийн түүх болон “Цагаан хэрэм”-ийн түүх, хагас зуун үргэлжилсэн үндэстний эрх чөлөөний тэмцлийн үр дүнд Ар Монгол нь бүрэн эрхт тусгаар тогтнолоо олсон ч Өвөр Монгол нь Манжийн эрхшээлээс Хятадын эрхшээлд орж “Өөртөө засах орон”-ны хэлбэрээр Хятадын нэг хэсэг болсон тухай мөн төрийн зүтгэлтнүүдийн явуулж байсан үйл хэргийн талаар судлаачдын бичсэн илтгэлүүдийг багтаажээ.

63.3(1)5

Х-50

ЭШФ Б-27185



Пунсалдулам Б. **Шинэ соёл Монголд төлөвшсөн түүх: XX зуун** / Хян. Ж.Болдбаатар.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 280х.- ISBN 978-99978-2-652-7.

Шинэ соёл хэрхэн төлөвшсөн түүхийг XX зууны Монголын нийгэм, эдийн засгийн хөгжлийн суурин дээр тавьж, түүнд нөлөөлсөн дотоод, гадаад хүчин зүйл, ялангуяа Монголын улс төрийн үйл явц, үзэл суртлын номлол хэрхэн нөлөөлснийг тодруулав. Үүний тулд соёлын хөгжлийн үе шат, бүтцийг тодорхой шалгуур зарчим дээр ангилан үзэж төлөвшилийн үйл явцыг гаргажээ.

63.3(1)7+71

П-885

/НУН унш-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-21610-21614

Барон Унгерний тухай баримт, дурдатгалууд / Эмхт. С.Л.Кузьмин; Орч. М.Д.Бадамням; Ред. Ц.Жамбалжамц.- УБ.: Монсудар, 2007.- 559х.- ISBN 99929-0-134-9.




Барон Унгерний тухай 150 гаруй баримт, тухайн үедээ Баронтой мөр зэрэгцэн тулалдаж явсан хүмүүсийн 28 дурдатгалыг 6 хэлнээс олж, цуглуулан эмхтгэсэн энэ номыг монгол хэлнээ орчуулан уншигч таны гарт хүргэж байна. Номонд орсон ихэнх материалууд урд нь нийтлэгдэж олны хүртээл болоогүй баримтууд байгаа нь Унгерн гэж ямар хүн байсныг, манай улсын түүхийн зурвасхан үеийн нэн ээдрээтэй цаг үеийг ухааран ойлгоход нэмэр болох буй заа.

63.3(2)-8

Б-313

Т-21324



Вотэрсон Ж. **Хятадыг хамгаалсан нь: 1209-1370** / Орч. Г.Батсүх; Ред. Я.Ганбаатар.- УБ.: Нэпко, 2017.- 242х.- ISBN 978-99978-51-26-0.

Энэхүү бүтээлд Дундад зууны хамгийн хүчирхэг эзэнт улсууд болох Монгол гүрэн хийгээд Хятадын Алтан улс, Сүн улс ба Мин улсын хоорондын домогт тэмцлийн тухай өгүүлнэ. Хойд зүгийн нүүдэлчидтэй өнө эртнээс чанагш бараг эцэс төгсгөлгүй дайтаж ирсэн Хятадын зөрчилдөөнийг өргөн утгаар нь өгүүлэхийн сацуу цэрэгжсэн нийгэм болоод армийнх нь зохион байгуулалт, удирдлага, хяналтын өөрчлөлт хувьсалын тухай мөн Хятад дахь дайн тэмцлийг олон улсын бодит нөхцөл байдалтай уялдуулж, орчин цагийн эхэн үеийн Евразийн түүхэнд Их гүрний хаад ба Хятадын эзэн хаад хоорондын сунжирсан тэмцэлдээний чухал ач холбогдлыг харуулжээ.


63.3(5Хят)

В-790

/НУН унш-5ш, ГНОФ-4ш/

ЭШФ Т-21539-21541

Мин улсын судар: Зботь / Орч. Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг; Эрхл. Д.Заяабаатар; Ред. Ц.Цэрэндорж.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- (Монгол Улсын Их Сургууль. Монгол Судлалын Хүрээлэн).



Энэ номонд эртний хятад хэлээрх “Мин Улсын судар” хэмээх түүхэн сурвалжийн “Уг тэмдэглэл” хэмээх хаадын түүхийг бүхэлд нь, Монголын түүх тэр дундаа бага хаадын үед холбогдох тулгуур мэдээ, 1368-1644 оны Зүүн Азийн харилцааг тусгасан хэсэг, Ил хаант улсын түүхийн Хүлэгү, Абага, Ахмед Тэгүдэр, Аргун ханы ширээнд залрах хүртэлх үеийг он дарааллын хэлбэрээр туурвисан “Кутбийн хавтаган дахь Монголчуудын элдэв сонин” хэмээх сурвалжийн бүрэн орчуулга, тайлбарыг оруулжээ.

63.3(5Хят)

М-553

Б.1.- 266х.- ISBN 978-99978-58-49-8. /НУН унш-8ш, ГНОФ-5ш/
ЭШФ Т-21636-21640

Б.2.- 243х.- ISBN 978-99978-58-49-8. /НУН унш-8ш, ГНОФ-5ш/
ЭШФ Т-21641-21645

Б.3.- 286х.- ISBN 978-99978-58-49-8. /НУН унш-8ш, ГНОФ-5ш/
ЭШФ Т-21646-21650



Хидэхиро О. **Энх-Амгалан хааны захидлууд** / Орч. П.Наранбаяр; Ред. Т.Мөнхцэцэг; Эрхл. Д.Заяабаатар.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 168х.- (Монгол Улсын Их Сургууль. Монгол Судлалын Хүрээлэн).- ISBN 978-99978-2-492-9.

Тайваны Хааны ордон музейд хадгалагдаж буй Чин улсын Энх-Амгалан хааны өөрийн гараар бичсэн захидлуудыг эрдэмтэн судлаачид судалж, сурвалжлан олны хүртээл болгожээ. Энэ захидлын эх сурвалж цөм 1696-1697 онуудад Галданыг дайлах үедээ өдөр тутмын үйл явдлаа нарийвчлан бичсэн захидлууд байв.

63.3(5)

Х-347

/НУН унш-8ш, ГНОФ-5ш/ ЭШФ Т-21621-21625

Баярсайхан Ж. **Монголын умард нутгийн буган хөшөөд** / Ред. У.Эрдэнэбат.- УБ.: Интерпресс, 2017.- 323х.- ISBN 978-99978-1-864-5.



Монголын буган хөшөөний тархалт, байршил, бүтэц, зохион байгуулалт, бүс нутгийн онцлог, бүтээх үйл явц, дүрсийн утга бэлгэдэл, он цаг, гарал үүслийн талаар нарийвчлан судалж, анх удаа олон улсын түвшинд нэгтгэн дүгнэж, шинэлэг санаа дэвшүүлсэн судалгааны томоохон бүтээл болжээ.

63.4(1)

Б-381

/НУН унш-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-21604-21606



Мөнх-Очир Д. **Цэцэрлэг мандал уулын аймгийн Гурвансайхан уулын хошууныхны ураг удам:** Угсаа гарвал судлал цуврал №6.- УБ., 2015.- 239х.- ISBN 978-99973-0-636-4.

Д.Мөнх-Очирын “Угсаа гарвал судлал” цуврал ном уншигчдийн гарт хүрч байна. Уг цувралын энэхүү номонд Сайн ноён хан аймгийн Ёст бэйлийн хошуу буюу одоогийн Өмнөговь аймгийн Баяндалай, Гурвантэс, Ноён, Сэврээ, Хүрмэн сумынхны удам угсаа, өвөг дээдсийг хойч үед нь таниулах зорилготой юм. Үндэсний Төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй “Хорин оны (1930 он) олон аймаг хошууд, хотын хүний насны ялгааны товчоо бүртгэл” гэсэн баримтанд Гурвансайхан уулын хошуу нь 1930 онд нийт 9020 хүн амтай байсан бөгөөд үүнээс 2850 эр хүн, 4639 эм хүн, 1529 лам байжээ.

63.5(1)

М-816

ЭШФ Б-28562

Мөнх-Очир Д. **Богд хан уулын аймгийн Хоёр-Өлзийт уулын хошууныхны ураг удам:** Угсаа гарвал судлал цуврал №8.- УБ., 2015.- 149х.- ISBN 978-99973-0-639-5.



Д.Мөнх-Очирын “Угсаа гарвал судлал” цуврал ном уншигчдийн гарт хүрч байна. Уг цувралын энэхүү номонд Өмнөговь аймгийн Манлай, Ханбогд сум, Дорноговь аймгийн Мандах сумынхны удам угсаа, өвөг дээдсийг хойч үед нь таниулах зорилготой юм. Үндэсний Төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй “Хорин оны (1930 он) олон аймаг хошууд, хотын хүний насны ялгааны товчоо бүртгэл” гэсэн баримтанд Хоёр-Өлзийт уулын хошуу нь 1930 онд нийт 4777 хүн амтай байсан бөгөөд үүнээс 1307 эр хүн, 2482 эм хүн, 988 лам байжээ.

63.5(1)

М-816

ЭШФ Б-28563



Мөнх-Очир Д. **Богд хан уулын аймгийн Хүнцэлцавчид, Дэлгэрхаан, Баян-Эрхэт уулын хошууныхан:** Угсаа гарвал судлал цуврал №9.- УБ., 2015.- 142х.- ISBN 978-99973-0-643-2.

Д.Мөнх-Очирын “Угсаа гарвал судлал” цуврал ном уншигчдийн гарт хүрч байна. Уг цувралын энэхүү номонд Төв аймгийн Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Лүн, Өндөрширээт, Эрдэнсант, Алтанбулаг, Баянхангай сумын хагас, Булган аймгийн Баяннуур, Бүрэгхангай сумын хагас болон Дашинчилэн сумынхны удам угсаа, өвөг дээдсийг хойч үед нь таниулах зорилготой юм. Үндэсний Төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй “Хорин оны (1930 он) олон аймаг

хошууд, хотын хүний насны ялгааны товчоо бүртгэл” гэсэн баримтанд Зогсоол жаргалант уулын хошуу нь 1930 онд нийт 10727 хүн амтай байсан ба үүнээс 4107 эр хүн, 5228 эм хүн, 1389 ламтай байсан бол Халиугчин боролзой уулын хошуу нь 11470 хнү амтай байсан бөгөөд үүнээс 5131 эр хүн, 5610 эм хүн, 729 ламтай, харин Хүнцэлцавчид уулын хошуу нь 8721 хүн амтай байсан бөгөөд үүнээс 3635 эр хүн, 4277 эм хүн, 809 ламтай байжээ.

63.5(1)

М-816

ЭШФ Б-28564

Мөнх-Очир Д. **Түшээт хан аймгийн Түшээт ханы хошууныхан:** Нэгдүгээр дэвтэр: Угсаа гарвал судлал цуврал №13.- УБ., 2016.- 168х.- ISBN 978-99962-76-58-3.



Д.Мөнх-Очирын “Угсаа гарвал судлал” цуврал ном уншигчдийн гарт хүрч байна. Уг цувралын энэхүү номонд Өвөрхангай аймгийн Хархорин, Бүрд, Зүйл сум бүтэн, Хужирт, Сант сумын хагас, Архангай аймгийн Хашаат сум бүтэн, Өгийнуур сумын хагас, Булган аймгийн Гурванбулаг, Рашаант сумынхны удам угсаа, өвөг дээдсийг хойч үед нь таниулах зорилготой юм. Үндэсний Төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй “Хорин оны (1930 он) олон аймаг хошууд, хотын хүний насны ялгааны товчоо бүртгэл” гэсэн баримтанд Хангай хайрхан уулын хошуу нь 1930 онд нийт 11597 хүн амтай байсан бөгөөд үүнээс 4376 эр хүн, 5694 эм хүн, 1527 лам байжээ.

63.5(1)

М-816

ЭШФ Б-28565



Мөнх-Очир Д. **Богд хан уулын аймгийн Хангай хайрхан уулын хошууныхан:** Хоёрдугаар дэвтэр: Угсаа гарвал судлал цуврал №14.- УБ., 2016.- 434х.- ISBN 978-99962-76-42-2.

Д.Мөнх-Очирын “Угсаа гарвал судлал” цуврал ном уншигчдийн гарт хүрч байна. Уг цувралын энэхүү номонд Өвөрхангай аймгийн Хархорин, Бүрд, Зүйл сум бүтэн, Хужирт, Сант сумын хагас, Архангай аймгийн Хашаат сум бүтэн, Өгийнуур сумын хагас, Булган аймгийн Гурванбулаг, Рашаант сумынхны удам угсаа, өвөг дээдсийг хойч үед нь таниулах зорилготой юм. Үндэсний Төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй “Хорин оны (1930 он) олон аймаг хошууд, хотын хүний насны ялгааны товчоо бүртгэл” гэсэн баримтаас харахад Хангай хайрхан уулын хошуу нь 1930 онд нийт 11597 хүн амтай байсан бөгөөд үүнээс 4376 эр хүн, 5694 эм хүн, 1527 лам байжээ.

63.5(1)

М-816

ЭШФ Б-28566

Мөнх-Очир Д. **Цэцэрлэг мандал уулын аймгийн Рашаант уулын хошууныхан:** Угсаа гарвал судлал цуврал №19.- УБ., 2017.- 240х.- ISBN 978-99978-0504-1.




Д.Мөнх-Очирын “Угсаа гарвал судлал” цуврал ном уншигчдийн гарт хүрч байна. Уг цувралын энэхүү номонд Хөвсгөл аймгийн Рашаант сум, Архангай аймгийн Цэцэрлэг, Жаргалант сумынхны удам угсаа, өвөг дээдсийг хойч үед нь таниулах зорилготой юм. Үндэсний Төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй “Хорин оны (1930 он) олон аймаг хошууд, хотын хүний насны ялгааны товчоо бүртгэл” гэсэн баримтаас харахад Рашаант уулын хошуу нь 1930 онд нийт 8646 хүн амтай, үүнээс 3503 эр хүн, 4211 эм хүн, 932 лам хүн байжээ.

63.5(1)

М-816

ЭШФ Б-28567



Мөнх-Очир Д. **Ханхэнтий уулын аймгийн Мөнх хаан уулын хошууныхан:** Угсаа гарвал судлал цуврал №20.- УБ., 2017.- 282х.- ISBN 978-99978-1-820-1.

Д.Мөнх-Очирын “Угсаа гарвал судлал” цуврал ном уншигчдийн гарт хүрч байна. Уг цувралын энэхүү номонд Дорнод аймгийн Баян-уул, Цагаан-Овоо, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Мөнххаан, Түмэнцогт, Хэнтий аймгийн Баян-Овоо, Норовлин сумынхны удам угсаа, өвөг дээдсийг хойч үед нь таниулах зорилготой юм. Үндэсний Төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй “Хорин оны (1930 он) олон аймаг хошууд, хотын хүний насны ялгааны товчоо бүртгэл” гэсэн баримтаас харахад Мөнххаан уулын хошуу нь 1930 онд нийт 10318 хүн амтай, үүнээс 3761 эр хүн, 5414 эм хүн, 1143 лам хүн байжээ.

63.5(1)

М-816

ЭШФ Б-28568

Мөнх-Очир Д. **Богд хан уул аймгийн Баруунбүрэн хан уулын хошууныхан:** Угсаа гарвал судлал цуврал №21.- УБ., 2017.- 131х.- ISBN 978-99978-1-820-1.



Д.Мөнх-Очирын “Угсаа гарвал судлал” цуврал ном уншигчдийн гарт хүрч байна. Уг цувралын энэхүү номонд Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумынхны удам угсаа, өвөг дээдсийг хойч үед нь таниулах зорилготой юм. Үндэсний Төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй “Хорин оны (1930 он) олон аймаг хошууд, хотын хүний насны ялгааны товчоо бүртгэл” гэсэн баримтаас харахад Баруунбүрэнхан уулын хошуу нь 1930 онд нийт 4725 хүн амтай, үүнээс 2060 эр хүн, 2237 эм хүн, 428 лам хүн байжээ.

63.5(1)

М-816

ЭШФ Б-28569

ЭДИЙН ЗАСАГ. ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Чимэг Д. **Монгол-Орос-Англи хэлний эдийн засгийн товч толь** / Хян. Ц.Янжмаа.- УБ.: Содпресс, 2018.- 377х.- ISBN 99978-1-748-8.

Тус толь бичигт эдийн засгийн шинжлэх ухаанд хамгийн өргөн хэрэглэгддэг түгээмэл шаардлагатай олон улсын эдийн засгийн харилцаа, гадаад худалдаа, маркетинг, менежмент, санхүү, зах зээл, нийлүүлэлт, банк, үнэт цаас, татвар гэх мэт олон давтамжтай үг, үг хэллэг, нэр томъёоноос гадна монголчуудын зан заншил, ахуй ба соёлын амьдрал, хөдөө аж ахуй, газар тариалантай холбоотой зарим нэгэн түгээмэл, өргөн хэрэглээний үг хэллэгийн орчуулгыг оруулжээ.

65я2

Ч-628

/НУН унш-3ш, ХЗС-5ш/

ЭШФ Б-28579-28580

Алтанзаяа Г., Мөнхзул Г. **Өртгийн бүртгэл: Сурах бичиг** / Хян. Р.Батжаргал.- 2 дахь хэвл.- УБ.: МУИС-ийн хэвлэх, 2014.- 298х.- ISBN 99929-9-075-10.



Энэхүү номыг хичээлийн сурах бичиг чиглэлээр бэлтгэсэн бөгөөд сургалтын хөтөлбөрт нийцсэн 11 бүлэгтэй, бүлэг тус бүрд онолын ойлголтыг жишээгээр бодож тайлбарласан төдийгүй өөрийгөө шалгах асуултууд, дасгал бодлогын хариуг арын хуудсанд хавсаргажээ. Уг номыг ашиглахдаа бүлэг бүрийн хувьд сэдвийн ерөнхий ойлголтыг өгөгдсөн схем, дүрслэл, тайлбарласан бодлогоос олж авснаар ярилцах асуудлуудаар ойлголтоо улам бататгаж, өөрийгөө шалгах асуултуудаар хэдэн хувийн мэдлэг эзэмшсэн болохоо мэдэж авна. Мөн дасгал, бодлого, шийдвэрлэх асуудлуудыг хийж гүйцэтгэснээр онолын болон практикийн мэдлэгийг зохих хэмжээнд эзэмших ажээ.

65.052я73

А-486

/НУН унш-3ш, БС-5ш/

ЭШФ Б-28511-28512



Буянтөгтох Х. **Банк, санхүүгийн харилцааны нууц** / Ред. Д.Баяндалай.- УБ.: Адмон, 2018.-240х.- ISBN 978-99978-2-599-5.

Энэ номонд мөнгөний үүсэл хөгжлөөс эхлээд банк, санхүү, валют, хадгаламж, зээл, түрээс гэх мэт санхүүгийн үйлчилгээний талаар ойлгомжтой энгийн үг хэллэгээр тайлбарласан нь сонирхогч хэн бүхэнд банк, санхүүгийн мэдлэг, мэдээлэл авахад тус болохуйц сонирхолтой ном болжээ.

65.26

Б-819

ЭШФ Б-28558-28559

Бурмаа Г. **Амьдралын даатгалын онол, арга зүйн асуудал**: Нэг сэдэвт бүтээл / Ред. Д.Дуламсүрэн, Р.Ринчинбазар.- УБ.: Түмэн Шанью, 2016.- 115х.- (Монгол Улсын Их Сургууль. Бизнесийн сургууль).- ISBN 978-99978-0-941-4.



Судлаач энэхүү нэг сэдэвт бүтээлдээ “Амьдралын даатгал”-ын онол, арга зүйн үндэс болон энэ даатгал нь хувь хүний амьдралд болоод улс орны эдийн засагт үзүүлэх үр ашиг, амьдралын даатгалыг хөгжүүлэх боломжийн талаар өгүүлжээ.

65.271

Б-769

/НУН унш-5ш/

ЭШФ Т-21670-21674



Бурмаа Г. **Арилжааны даатгал**.- УБ., 2016.- 180х.- ISBN 978-99978-3-025-8.

Энэхүү сурах бичигт даатгалын онол, арга зүйн үндэс, онцлог, аргачлал, зарчмуудыг энгийн ойлгомжтой байдлаар тусгаж, жишээгээр тайлбарлан оруулжээ. Уг сурах бичиг нь их, дээд сургуульд суралцагч оюутнууд, банк, даатгал, санхүүгийн салбарт ажиллагсадад мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд үнэтэй хувь нэмэр болох ажээ.

65.271я73

Б-769

/НУН унш-5ш/

ЭШФ Б-28628-28632

Оргилон Д. **Ажлын дизайн**: Онол ба хэрэглээ / Ред. Х.Пүрэвдагва.- УБ.: ШУТИС-ийн хэвлэх, 2017.- 146х.- ISBN 978-99978-1-462-3.



Ажил, ажлын зохион байгуулалт бол байгууллагыг зохион байгуулах үйлийн анхдагч нь юм. Бизнесийн удирдлагын доктор Доржсүрэнгийн Оргилонгийн туурвисан энэхүү бүтээл нь аливаа байгууллагыг сайтар зохион байгуулж, үр ашигтай ажиллуулахад байгууллагын удирдлага, менежер, мэргэжилтнүүдэд тун хэрэгтэй гарын авлага болжээ.

65.290-2

О-417

/НУН-3ш, БС-5ш/

ЭШФ Б-28509-28510



Фермерийн аж ахуйн менежмент / Л.Наранхүү, З.Ядмаа, Н.Чинзориг ба бус.; Ред. Л.Наранхүү.- УБ.: Ордпресс, 2017.- 536х.- ISBN 978-99978-0-643-7.

Энэхүү сурах бичгийг судалснаар XXI зууны фермерийн аж ахуйн менежментийн хандлага, менежерийн нэг үндсэн үүрэг болох шийдвэр гаргах үйл явц, зөв шийдвэр гаргахад ашиглах мэдээллийн тогтолцоо, түүнийг бэлтгэх, бизнесийн үйл ажиллагаанд хяналт тавих гол арга болох нягтлан бодох бүртгэл, менежментийн шинжлэх ухаанд хэрэглэгддэг нэр томъёо, фермерийн аж ахуйн бизнесийн үйл ажиллагаанд ашиглагдах нөөцийн менежментийн тухай, хөдөө аж ахуйн гол салбар болох мал аж ахуй, ургамлын аж ахуйн менежментийн асуудлуудын талаар мэдлэг олж авах болно.

65.321

Ф-434

/НУН унш-3ш, БС-5ш/

ЭШФ Т-21554-21555

Минфү Л. **Хятад мөрөөдөл**: Америк туйлт ертөнцийн дараах хүчний хуваарилалт, стратеги байр суурь / Орч. А.Алимаа.- Анхны хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 355х.- ISBN 978-99978-51-33-8.




XXI зууны дэлхийн тэргүүлэгч гүрэн болохын төлөөх Хятад, Америкийн өрсөлдөөн нь түүхэнд байгаагүй хүчний тулаан бөгөөд хэн ялахаас үл хамааран хоёр их гүрэн хөгжин дэвшиж, хүний нийгэм олон шинэ зорилго, зорилттой тулгаран, дэлхий ертөнцийн дүр төрх ч өөрчлөгдөхөд эерэг түлхэц болж болох шинэ эрин зууны хөгжлийн тухай өгүүлжээ.

65.9(Хят)

М-564

/НУН унш-5ш, ГНОФ-6ш/

ЭШФ Б-28541-28543



Пилсбюри М. **Зуун жилийн марафон**: Америкийн байр суурийг эзэлж, дэлхийн супер гүрэн болох Хятадын нууц стратеги / Орч. Б.Оюунчимэг.- Анхны хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 383х.- ISBN 978-99978-51-34-5.

Зохиолч 2049 он гэхэд Хятад улс хэрхэн Америкийн байр суурийг эзэлж, дэлхийд тэргүүлэх нууц стратеги баримталж ирснийг, Хятадын цэрэг тагнуулын агентлагуудын баримт бичиг, хэлсэн үг, ном бүтээл зэргийг судлан үзэж, Хятадын стратегийн тулгын чулуу болсон Хятадын уламжлалт Төр удирдах ухааны сургаал чухам юу болохыг, АНУ-ын Засгийн газар энэ “Хятад мөрөөдөл” биеллээ олоход нь ажиг сэжиг авалгүй хэрхэн тусалж ирсэн тухай өгүүлсэн байна.

65.9(Хят)

П-324

/НУН унш-5ш, ГНОФ-6ш/

ЭШФ Б-28538-28540

УЛС ТӨР. УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН

Ардчиллын үндэс: Эрх мэдэл, хувийн орон зай ба нууц, үүрэг хариуцлага шударга, ёс: ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад зориулав: Брайль ном.- УБ., 2018.- (Иргэний боловсролын төв).

Ардчиллын үндэс болсон эрх мэдэл, хувийн орон зай ба нууц, үүрэг, хариуцлага, шударга ёсны тухай энэ номыг харааны бэрхшээлтэй сурагчдад зориулан гаргажээ.



66.0
А-727

Дэвт.1.- 238х.	ЭШФ Т-21687
Дэвт.2.- 186х.	ЭШФ Т-21688
Дэвт.3.- 190х.	ЭШФ Т-21689
Дэвт.4.- 207х.	ЭШФ Т-21690



Бэвир К. Засаглал: Тун товчхон танилцуулга / Орч. Т.Ариунсанаа.- Анхны хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 137х.- ISBN 978-99978-51-32-1.

“Засаглал” гэж юу болох, Засгийн газраас ямар ялгаатай, “Сайн засаглал”, “Муу засаглал” гэж юуг хэлдэг вэ?, Засаглалыг хаана юунд хэрэглэж болох тухай Засаглалын онол болоод тэдгээр нь нийгмийн зохицуулалт, дүрэм журмын хэв маягтай хэрхэн холбогддог, Засаглал нь хувийн хэвшил, олон нийт, олон улсын харилцаанд яаж нөлөөлж байдаг талаар мэргэжлийн түвшинд тун товчхон тодорхой бичигдсэн часхийсэн атлаа авсаархан, уншигчдын халаасны толь болно гэж энэ номын талаар судлаачид тодорхойлжээ.

66.0
Б-920

/НУН унш-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-28535-28537

Бор Ж., Баатар Д. Монголын үндэсний аюулгүй байдал: Уламжлалт бодлого ба арга барил, геополитикийн орчин өөрчлөгдөж ирсэн үе шатууд, шинэ мянганы сорилтууд.- УБ.: Адмон принт, 2016.- 232х.- ISBN 978-99978-0-623-9.



Төр улс анх үүсэн бий болсон цаг мөчөөс гадаад, дотооддоо улс орныхоо аюулгүй байдлаа хангах бодлого гэдэг зүйл гарч ирсэн байна. Энэ чухал бөгөөд нарийн төвөгтэй ажлыг ямар нэгэн байдлаар хөнгөвчлөх үүднээс улс төрийн сэтгэлгээ, гадаад бодлогын үйл ажиллагааны загварчлал ба чиг шугам гарч иржээ. Гадаад бодлогыг өөртөө ашигтайгаар зөв хөтөлж явуулах нь тухайн улсын дотоод байдал буюу дотоод бодлого, түүнийг тойрон бүрэлдэн тогтсон гадаад орчны онцлог, олон улсын харилцаанд бүрэлдэн тогтсон нөхцөл байдлаас шалтгаалдаг ажээ. Өөрөөр хэлбэл


төр, улс оршин тогтнож чадах эсэх нь гадаад дотоод үйл ажиллагаанаас ихээхэн шалтгаалдаг билээ.

66.4(1)

Б-600

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-28526-28528



Баярхүү Д. **Тахрирын хоёрдугаар хувьсгал**: Дэлхийн III дайнд өдөн дуудсан “Арабын хавар”.- 2 дахь хэвл.- УБ.: Нэпко, 2013.- 410х.- ISBN 978-99962-66-85-0.

Энэ ном нь Венийн конвенцэд заагдсан зарим үүргийг Элчин сайд, Элчин сайдын яам хэрхэн хэрэгжүүлсэн талаархи дипломатчийн тэмдэглэл, эмхтгэл ном юм. Тодруулбал Элчин сайдын өдрийн тэмдэглэл хэлбэрээр бичигдсэн түүхэн зохиол ажээ. "Түүхэн" гэдэг утга нь 2011 онд Египетэд өрнөж улмаар Арабын ертөнцөд жинтэй нөлөөлсөн Арабын хавар гэх түүхэн тэр их хувьсгалт үйл явцын амьд гэрч болсноо цаасан дээр буулгасан явдал бөгөөд Сирийн иргэний дайнтай салшгүй холбоотой, түүнээс улбаалан цаашаа үйл явц өрнөж буй гэдгээр Ирак, Курд, Иран, Афганистаныг тус тусад нь бүлэг болгон шинээр оруулж, Аль-Каеда гэх олон улсын террорист сүлжээ, 2013 онд Иранд явагдсан Ерөнхийлөгчийн сонгууль, түүний үр дүнг хөндөн бичсэн байна.

66.49

Б-385

/НУН унш-5ш/

ЭШФ Б-28581-28585

ТӨР ЭРХ. ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН

Амархүү О. **Эрх зүйн онол**: Хялбаршуулсан сурах бичиг / Хян. Д.Лүндээжанцан, Д.Оюунцэцэг.- УБ.: Адмон принт, 2018.- 320х.- ISBN 978-99978-2-393-9.



Зохиогч энэхүү номондоо хууль бүтээх, системчлэх, тайлбарлах арга ажиллагаа, тэр бүхэнтэй байнга уялдан холбогддог эрх зүйн онол, арга зүйн олон асуудлыг нэгэн бүхэллэг болгож, шинжлэх ухааны үүднээс маш ойлгомжтой, хамгийн энгийнээр өгүүлсэн нь хууль зүйн чиглэлээр суралцагч оюутнууд, судлаачид, хуулийн ажилтнууд болон хууль сонирхогч энгийн иргэд ч уншихад хэрэгцээтэй бүтээл болжээ.

67.0я73

А-519

/НУН унш-4ш, ГНОФ-3ш, ХЗС-10ш/

ЭШФ Б-28506-28508



Цэрэнбал Г., Цэнгэл Х. **Хөх нуурын чуулганы цаазын бичиг**: Дээд Монголын түүх, соёлын цуврал бичиг / Хян. Б.Нямдорж, А.Батсуурь.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 412х.- (Монгол улс Ховд их сургууль. БНХАУ Хөх нуурын үндэсний их сургууль).- ISBN 978-99978-4-184-1.

Хөх нуурын чуулганы цаазын бичиг хэмээх цаазын бичиг бол улсын дотоод, гадаадын эрдэмтэн мэргэдэд ерөөс мэдэгдээгүй Монголын эртний хууль цаазын дурсгал бичгийн нэг бөгөөд тус цаазын бичиг нь Дөрвөн Ойрадын хошууд аймгийн гэгээн Гүүш хаан 1637 оноос хойш аймаг албатаа дагуулан Хөх нуур, Төвдийн өндөрлөгт орж ирээд 48 жил болсны дараа 1685 онд Хөх нуурын чуулган дээр тунгаан баталсан цаазын бичиг юм. Энэхүү цааз тухайн үеийн Хөх нуурын монголчуудын улс төр, хууль цааз, аж ахуй, шашин шүтлэг, соёл, зан заншил зэрэг нийгмийн амьдралын олон талыг нилээд өргөн хамарсан өвөрмөц онцлог бүхий орон нутгийн чанартай хууль цаазын бичиг ажээ.

67.3(1)

Ц-969

/НУН унш-2ш/

ЭШФ Т-19356-19358

Төрийн захиргаа, засаглал: Төрийн албан хаагчдад зориулсан гарын авлага-1 / Эмхт. Ш.Батсүх.- УБ., 2017.- 366х.

“Төрийн захиргаа” сэтгүүлд нийтлэгдсэн өгүүллүүдийг төрийн албан хаагчид, судлаачид, энэ чиглэлээр суралцагчид болон сонирхсон бүх хүмүүст зориулан цуврал болгон хүргэж байна. Энэ эмхэтгэлд захиргааны шинжлэх ухааны үүсэл, хөгжил, онол, үзэл баримтлал, захиргааны шинэчлэлийн асуудлууд, мөн засаглалтай холбоотой өгүүллүүдийг оруулжээ. Энэхүү цуврал гарын авлага нь төрийн албан хаагчдад онол, арга зүйн суурь мэдлэг олгохоос гадна бусдын туршлагаас суралцах, тэднээс санаа авч ажил амьдралдаа ашиглах боломжийг олгож байна.

67.401

Т-594

/НУН унш-5ш, ОУХНУС-5ш/

ЭШФ Т-21556-21558



Төрийн алба, хүний нөөц: Төрийн албан хаагчдад зориулсан гарын авлага-2 / Эмхт. Ш.Батсүх.- УБ., 2017.- 150х.

